



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/212

Арвайхээр

Нийгмийн ажилтны ёс зүйн салбар хороо  
байгуулах, салбар хорооны дүрэм батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Нийгмийн халамжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм" 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 33 дугаар тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын "Дүрэм шинэчлэн батлах тухай" 2020 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/151 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, нийгмийн ажилтнуудын нийгмийн ажил үйлчилгээ үзүүлэх явцад мөрдөх ёс зүйн хэм хэмжээ, мэргэжлийн үйлчилгээ, үйл ажиллагаанд баримтлах үнэт зүйлс, зарчмыг тодорхойлж, үүрэг хариуцлагыг сайжруулах, хяналт тавьж, дүн шинжилгээ хийх, шийдвэрлэхтэй холбоотой харилцааг зохицуулах Нийгмийн ажилтны ёс зүйн салбар хороог байгуулж, салбар хорооны бүрэлдэхүүнийг 1 дүгээр, салбар хорооны дүрмийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

2.Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд Нийгмийн ажилтны ёс зүйн салбар хорооны үйл ажиллагааг дэмжиж, ёс зүйн дүрмийг нийт нийгмийн ажилтнуудад сурталчлан, мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр ханган ажиллахыг Нийгмийн ажилтны ёс зүйн салбар хорооны дарга (Б.Сайнжаргал)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0394

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны ... дүгээр  
сарын ...-ны өдрийн ... дугаар  
захирамжийн 1 дүгээр хавсралт



## НИЙГМИЙН АЖИЛТНЫ ЁС ЗҮЙН САЛБАР ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Салбар хорооны дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Эрүүл мэндийн газрын дарга

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга

Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газрын дарга

Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн Нийгмийн эрүүл мэндийн ажилтны төлөөлөл

Ерөнхий боловсролын сургуулийн Нийгмийн ажилтны Өвөрхангай аймаг дахь салбар зөвлөлийн төлөөлөл

Нарийн бичгийн дарга:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

-oOo-

Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр  
сарын 10-ны өдрийн 10 дугаар  
захирамжийн 2 дугаар хавсралт



## НИЙГМИЙН АЖИЛТНЫ ЁС ЗҮЙН САЛБАР ХОРООНЫ ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү дүрмийн зорилго нь Нийгмийн ажилтны ёс зүйн салбар хорооны үйл ажиллагааг зохицуулахад оршино.
- 1.2. Нийгмийн ажилтны мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой ёс зүйн алдаа, зөрчлийг шийдвэрлэх зорилгоор нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлдэг төр, төрийн бус байгууллагуудын төлөөллөөс бүрдэнэ.
- 1.3. Нийгмийн ажилтны ёс зүйн салбар хорооны үндсэн үйл ажиллагааны хэлбэр нь хурал байна.
- 1.4. Нийгмийн ажилтны ёс зүйн салбар хороо нь (цашид хороо гэх) холбогдох хууль, дүрэм, журам болон Нийгмийн ажилтны үндэсний хорооны ёс зүйн дүрмийг мөрдлөг болгон ажиллана.

### Хоёр. Салбар хорооны бүтэц, бүрэлдэхүүн, үйл ажиллагааны чиглэл

#### 2.1. Бүтэц, бүрэлдэхүүн:

- 2.1.1. Хороо нь 7-9 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулна.
- 2.1.2. Хорооны дарга, гишүүн, нарийн бичгийн даргыг 3 жилийн хугацаатай томилно.
- 2.1.3. Хорооны хяналтын хорооны бүрэлдэхүүнийг Нийгмийн ажилтны ёс зүйн үндэсний хорооны дарга батална.
- 2.1.4. Хорооны бүрэлдэхүүн олон талт төлөөлөл буюу тус дүрмийн 1.2-т заасан төлөөллөөс бүрдэнэ.
- 2.1.5. Хороо нь жишиг дүрэмтэй нийцүүлэн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн эрх, үүрэг, хурлын дэг, үйл ажиллагааг тусгасан өөрийн дүрмээ боловсруулан баталж, мөрдөнө.
- 2.1.6. Хороо нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.
- 2.1.7. Хорооны гишүүн, дарга, нарийн бичгийн дарга, хүндэтгэн үзэх шалтгаантай буюу өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх тохиолдолд томилгоог нөхөн томилж болно.

#### 2.2. Салбар хорооны үйл ажиллагааны чиглэл:

- 2.2.1. Нийгмийн ажилтны ёс зүйн алдаа, зөрчлийг шийдвэрлэх
- 2.2.2. Салбар хороогоор шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Үндэсний хороонд уламжлах
- 2.2.3. Нийгмийн ажилтнуудын ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих

3.2.7. Жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан үндэсний хороонд жилийн ажлын тайлан тавих

Дөрөв. Санхүүжилт

4.1. Хорооны гишүүдийн цалин хөлс, урамшуулал, үйл ажиллагааны зардлыг аймгийн төсөв, хөтөлбөрт тусгах байдлаар санхүүжүүлнэ.



-oOo-

НИЙГМИЙН АЖИЛТНЫ ЁС ЗҮЙН САЛБАР ХОРООНЫ  
ГИШҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ



№	Овог, нэр	Албан тушаал	Мэргэжил	Холбоо барих	
				Цахим хаяг	Утасны дугаар
1.	Бямбадоржийн Сайнжаргал	Нийгмийн бодлогын хэлтсийн дарга	Багш	Sainaa_0606@yahoo.com	99067603
2.	Адъяасүрэнгийн Отгонцэцэг	Хууль эрх зүйн хэлтсийн дарга	Эрх зүйч	otgontsesteg@ov.gov.mn	99199576
3.	Даажамбын Шиваанүрдэв	Эрүүл мэндийн газрын дарга	Эмч	shivaanaa@yahoo.com	99027701
4.	Нэргүйн Чимэддорж-Ойдов	Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга	Багш	oidovnergui@gmail.com	99143444
5.	Нэргүйн Цэвээндулам	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Багш-орчуулагч	Tseveendulam1617@gmail.com	99055814
6.	Цэрэндоржийн Эрдэнэсүрэн	Арвайхээр сумын Засаг даргын орлогч	Экологич	eesvv9149@gmail.com	99039149
7.	Ганболдын Энхсайхан	Арвайхээр сумын ЕБ-ын 1 дүгээр сургуулийн Нийгмийн ажилтан	Нийгмийн ажилтан	Saikhanaa237@gmail.com	88570808
8.	Батмөнхийн Энхцэцэг	Богд сумын Эрүүл мэндийн төвийн Нийгмийн эрүүл мэндийн ажилтан		tsetsgee3579@gmail.com	99803579
9.	Эрдэнэ-Очирын Хоролсүрэн	Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн	Багш	Khnhorloo0127@gmail.com	99795886